

## ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.21-д “Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, татварын таатай орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан иргэд, аж ахуйн нэгжүүд татварын хууль тогтоомжийг сайн дураараа мөрдөх явдлыг дэмжих, татварын албаны зөвлөн туслах үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, татвар төлөгчдөд тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Үүнтэй холбогдуулан Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup>.1.1-д заасан гаалийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, иргэн хуулийн этгээдэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгардаг нийтлэг асуудлууд, үүсдэг эрсдэлийн талаарх мэдээллийг агуулсан заавар, зөвлөмжөөр тогтмол хангах, төр, хувийн хэвшил, худалдаа, аж үйлдвэрийн танхим болон мэргэжлийн холбоодтой хамтран сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохицуулахаар Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар гаалийн хууль тогтоомжийг сайн дураар дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлж, иргэн, хуулийн этгээд гаалийн байгууллагын хооронд үүсдэг хуулийн хэрэглээтэй холбоотой маргааны тоо буурах, гаалийн хууль тогтоомжийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн иргэн, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор гааль, татварын албаны үйл ажиллагааг уялдуулж, нээлттэй ил тод болгох, хяналт шалгалтын давхардлыг арилгах зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэг:**

“97.4.Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн санхүүжилттэй зам, барилга байгууламжийн ажилд ашиглах машин механизм, техник, тоног төхөөрөмжийн хувьд энэ зүйлийн 97.1-д заасан хугацааг гэрээний хугацаанд багтаан нэг жил хүртэлх хугацаагаар сунгаж болно.”

**2/234 дүгээр зүйлийн 234.3 дахь хэсэг:**

“234.3.Энэ зүйлийн 234.1-д заасан хугацаа нь гаалийн мэдээллийн систем дэх мэдүүлэг тус бүрээр олон нийтэд нээлттэй байх ба мэдүүлэгчийг таних боломжгүй байна.”

**3/249 дүгээр зүйлийн 249.5, 249.6, 249.7 дахь хэсэг:**

“249.5.Гааль, татварын алба нь тухайн татварын жилд мэдүүлэгчийн үйл ажиллагаанд давхардуулан хяналт шалгалт хийхгүй.

249.6.Мэдүүлэгчийг эрсдэлтэй гэж тооцсон тохиолдолд хяналт шалгалтыг гааль, татварын алба хамтран хэрэгжүүлнэ.

249.7.Гаалийн байгууллага хяналт шалгалт хийх талаар мэдүүлэгчид ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө бичгээр, эсхүл цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэнэ.”

**4/252 дугаар зүйлийн 252.9, 252.10 дахь хэсэг:**

“252.9.Магадлан шинжилгээгээр ангиллын код тодорхойлон улсын хилээр оруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.2-т заасан тохирлын гэрчилгээ бүхий барааны нэр, зориулалт, марк, модель, гарал үүслийн улс, үйлдвэрлэгч, илгээгч өөрчлөгдөөгүй тохиолдолд уг барааг улсын хилээр дахин оруулахад мэдүүлэгчийн гадаад худалдааны гэрээнд заасан тоо хэмжээний хүрээнд магадлан шинжилгээ хийхгүй.

252.10.Энэ зүйлийн 252.9 дэх хэсэгт тарифын бус хязгаарлалттай бараа хамаарахгүй.”

**5/289 дүгээр зүйлийн 289.5 дахь хэсэг:**

“289.5.Гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор гаалийн байгууллага нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл авах боломжтой байна.”

**2 дугаар зүйл.**Гаалийн тухай хуулийн 240 дүгээр зүйлийн 240.2 дахь хэсгийн “хэрэгжүүлэхдээ” гэсний дараа “гааль, татварын албаны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн” гэж, 249 дүгээр зүйлийн 249.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “эрсдэлд үндэслэн” гэж, 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>.1.1 дэх заалтын “тавих” гэсний дараа “, иргэн, хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Гаалийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“12 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх гаалийн зөвлөн туслах үйлчилгээ**

12.1.Гаалийн байгууллага нь энэ хуулийн 269<sup>1</sup>.1.1-д заасан чиг үүргээ доор дурдсан байдлаар хэрэгжүүлнэ:

12.1.1.иргэн, хуулийн этгээдийг гаалийн хууль тогтоомж хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, эрсдэлийн мэдээллийг агуулсан гарын авлага, заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлэх, танхимын болон цахим хэлбэрийн сургалтад хамруулах;

12.1.2.гаалийн хууль тогтоомж, гаалийн бүрдүүлэлтийн маягтад өөрчлөлт орсон тохиолдолд төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэн, эсхүл улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээс хойш ажлын 15 өдрийн дотор тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд анхаарах мэдээллийг агуулсан зөвлөмжийг иргэн, хуулийн этгээдэд цахим системээр хүргүүлэх, сургалт зохион байгуулах;

12.1.3.татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин буурах нөхцөл бүрдсэн, эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд энэ талаар татвар төлөгчид мэдэгдэж, зөрчлөө арилган эрсдэлээс сэргийлэх боломж олгох;

12.1.4.гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гаалийн албан татварын хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх боломжийн талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор хиймэл оюун ухаан болон их өгөгдөлд суурилсан, 24 цагийн турш тасралтгүй ажиллах автомат хариулагчийг ажиллуулах;

12.1.5.худалдаа, аж үйлдвэрийн танхим, мэргэжлийн холбоо, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын байгууллага, гадаад улсын дипломат болон консулын байгууллагаас гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой асуудлаар зөвлөгөө, сургалт авахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

12.1.6.олон нийтийн гадаад худалдаа, гаалийн мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гаалийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор төр, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодтой хамтран сургалт, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах, гарын авлага, зөвлөмж, аргачлалаар хангаж ажиллах;

12.1.7.гаалийн байгууллагын цахим хуудсанд гаалийн хууль тогтоомжийг англи болон монгол хэлээр байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтийг хамарсан сурталчилгаа, сургалт, мэдээллийн нэвтрүүлэг зохион байгуулах, нийтлэл гаргах;

12.1.8.хуулиар зөвшөөрөгдсөн бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

12.2.Энэ зүйлийн 12.1-д заасан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайл үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангасан байна.

12.3.Гаалийн байгууллага нь энэ зүйлийн 12.1-д заасны дагуу зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөө, гарын авлага, зөвлөмж, хөтөлбөр мэдээллийг гаалийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.

12.4.Энэ зүйлийн 12.1.5-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гаалийн байгууллага тухайн салбарын мэргэжлийн холбоотой хамтран хэлэлцүүлэг, сургалтын хөтөлбөр боловсруулан, товыг зарлан, 45-аас доошгүй хоногийн хугацаанд хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулна. Хэлэлцүүлэг, сургалтын тов, хөтөлбөр нь худалдаа, аж үйлдвэрийн танхим, тухайн салбарын мэргэжлийн холбоо болон олон нийтэд нээлттэй байна.

**4 дүгээр зүйл.**Гаалийн тухай хуулийн 294<sup>1</sup> дүгээр зүйлийн 294<sup>1</sup>.1 дэх хэсгийн “татварын үнийн дүнгээс хугацаа хожимдуулсан хоног тутамд 0.3 хувийн хүү ногдуулах бөгөөд энэ заалтын "хүү" гэсэн ойлголт нь Иргэний хуулийн "анз" гэсэн ойлголтод үл хамаарна” гэснийг “татварт Татварын ерөнхий хуульд заасны дагуу алданги тооцно” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийн 3 дугаар зүйлийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын  
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

Энэ хүрээнд гааль, татварын албаны үйл ажиллагааг уялдуулж, нээлттэй ил тод болгох, татвар төлөгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх зорилгоор Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд барааг хилээр түргэн шуурхай нэвтрүүлэх зорилгоор урьдчилсан бүрдүүлэлт хийж, татвараа төлөх, гаалийн болон бусад татвар төлөх банкны баталгаа, мөнгөн хөрөнгийн барьцааг ногдуулсан татварын хэмжээгээр гаргах зохицуулалтыг тусгасан. Гаалийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах зорилгоор гаалийн үнийг шалгах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байхаар заасан. Түүнчлэн гаалийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, алдангийн асуудлыг бусад татварын хууль тогтоомжтой нийцүүлсэн.

Улмаар гаалийн татвар, тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт гаргах, санал боловсруулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, гаалийн тарифын зөвлөлийг Монголын үндэсний танхимаар ахлуулахаар хуулийн төсөлд тусгасан.

---o0o---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.10 дахь хэсэг нэмсүгэй:

“8.10. Гаалийн үнийг шалгах үйл ажиллагаа нь гаалийн мэдээллийн систем дэх мэдүүлэг тус бүрээр олон нийтэд нээлттэй байх ба мэдүүлэгчийг таних боломжгүй байна.”

**2 дугаар зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “баталгаа нь” гэсний дараа “барааны хувьд” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “4.1.11-д” гэснийг “12.1.3-т” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Монголын үндэсний танхим” гэж, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн байх бөгөөд түүнийг Засгийн газраас томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооных” гэснийг “Монголын үндэсний танхимын ерөнхийлөгч” гэж, мөн зүйлийн 6.3 дахь хэсгийн “гааль, татвар” гэснийг “гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “тарифын” гэснийг “тариф, татварын” гэж, “валютын ханшийг” гэснийг “татварыг” гэж, мөн зүйлийн 35.6 дахь хэсгийн “хувь,” гэснийг “хувь” гэж, 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 9.3-т” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “татварын төлбөрийн дүнгийн 0,3 хувиар тооцон хоног тутам хүү төлнө” гэснийг “татварт Татварын ерөнхий хуульд заасны дагуу алданги тооцно” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “төгрөгийн гадаад валюттай харьцах ханш болон” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг, 38 дугаар зүйлийн 38.1.13 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний  
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын татварын тогтолцоо, хууль эрх зүйн орчныг сайжруулах, татвар төлөгчдийг мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь татварын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх, татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг татварын мэргэшсэн зөвлөхүүдийн оролцоотойгоор эрчимжүүлэх, зөвлөх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэнд зөвхөн хуулийн этгээдээр үзүүлэх бус хувь хүн, хуулийн этгээд эрх бүхий байгууллагад мэдэгдсэний үндсэнд уг үйлчилгээг эрхлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоход чиглэж байна. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, уг үйлчилгээний мэргэжлийн түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор мэргэшсэн зөвлөхийн эрхийн зэрэглэлийг шатлан ахиулах зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн мэргэжлийн холбоо болох Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн засаглалыг сайжруулж, ил тод болгох болон мэргэшсэн зөвлөхүүдийг татварын албатай хамтран сургалт, мэдээлэл өгөх үйл ажиллагаанд оролцуулах, татвар төлөгчдөд хууль тогтоомжийн талаар ойлголт өгөх үүргийг тодорхой болгох зохицуулалтыг орууллаа.

Энэхүү хуулийн төсөл нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжтэй болгох, иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын боловсролыг дээшлүүлэх, улмаар татварын албаны үйл ажиллагааг дэмжиж, татварын орчныг илүү ойлгомжтой, тогтвортой болгох ач холбогдолтой. Хуулийн төсөл батлагдсанаар татвар төлөгчид мэргэжлийн зөвлөгөө авах хүртээмж илүү нэмэгдэж, тэдгээрийг татварын эрсдэлээс урьдчилан сэргийлж, татварын хууль тогтоомжийн хэрэгжилт сайжрах үр дүн гарна гэж үзэж байна.

---о0о---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/10 дугаар зүйлийн 10.2, 10.3 дахь хэсэг:**

“10.2.Энэ зүйлийн 10.1-д заасан шаардлагыг хангасан зөвлөх үйлчилгээ эрхлэхийг хүссэн этгээд нь Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр зөвлөх үйлчилгээг эрхэлнэ.

10.3.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь дараах баримт бичгийг өөрийн цахим хуудсанд олон нийтэд байнга нээлттэй байршуулна:

- 10.3.1.татварын мэргэшсэн зөвлөх, эцсийн өмчлөгчийн анкет;
- 10.3.2.хуулийн этгээдийн дүрэм;
- 10.3.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ.”

#### **2/15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалт:**

“15.1.6.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчлөх эрхийн эсрэг, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй.”

#### **3/18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт:**

“18.2.7.татвар төлөгчийг мэдээ, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах ажлыг татварын албатай хамтран зохион байгуулах;”

#### **4/18<sup>1</sup> дүгээр зүйл.Нийгэмлэгийн засаглал**

“18<sup>1</sup>.1.Нийгэмлэгийн өөрөө удирдах ёсны эрх барих дээд байгууллага нь Нийгэмлэгийн Их хурал байна.

18<sup>1</sup>.2.Нийгэмлэгийн Их хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 18<sup>1</sup>.2.1.Нийгэмлэгийн дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 18<sup>1</sup>.2.2.Нийгэмлэгийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, сахилгын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн цалингийн хэмжээг тогтоох;

18<sup>1</sup>.2.3.Нийгэмлэгийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, сахилгын зөвлөлийн ажиллах журмыг батлах;



18<sup>1</sup>.2.4.Нийгэмлэгийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг сонсох, дүгнэх;

18<sup>1</sup>.2.5.Нийгэмлэгийн гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг тогтоох;

18<sup>1</sup>.2.6.Нийгэмлэгийн дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

18<sup>1</sup>.3.Нийгэмлэгийн ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх ба 1 удаа улируулан сонгож болно.

18<sup>1</sup>.4.Энэ зүйлийн 18<sup>1</sup>.3-т заасан Нийгэмлэгийн Ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх, үүргийг Нийгэмлэгийн дүрмээр тогтооно.

18<sup>1</sup>.5.Нийгэмлэгийн Их хурал үйл ажиллагаагаа хуралдааны хэлбэрээр явуулах бөгөөд ээлжит Их хурал хоёр жил тутам хуралдана. Их хурлын ээлжит бус хуралдааны журмыг нийгэмлэгийн дүрмээр тогтооно.

18<sup>1</sup>.6.Нийгэмлэгийн Их хуралд оролцох татварын мэргэшсэн зөвлөхүүдийн төлөөлөгчдийг сонгох журмыг нийгэмлэгийн дүрмээр тогтоох бөгөөд төлөөлөгчдийн дийлэнх олонх оролцсоноор их хурал хүчин төгөлдөр болно.”

**2 дугаар зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт:**

“3.1.5.“татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч” гэж татварын мэргэшсэн зөвлөх болон татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийг;”

**2/11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт:**

“11.1.5.татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчид татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;”

**3/15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт:**

“15.1.4.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчлөх эрхийн эсрэг, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;”

**4/16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт:**

“16.1.5.Татварын ерөнхий хуулийн 77<sup>1</sup> дүгээр зүйлийн 77<sup>1</sup>.6-д заасан зөвлөн туслах үйл ажиллагааг татварын албатай хамтран зохион байгуулах;”

**3 дугаар зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.5 дахь заалтын, 11 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтын, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн, 20.3 дахь хэсгийн “итгэмжлэгдсэн хуулийн” гэснийг “мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “, татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдэд ажиллах татварын

итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг” гэснийг “хувь хүнийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “үүсгэн байгуулагч” гэснийг “эцсийн өмчлөгч” гэж, 10.1.2 дахь заалтын “гурав” гэснийг “хоёр” гэж, 10.1.8 дахь заалтын “хоёр, түүнээс” гэснийг “нэгээс” гэж, мөн заалтын “итгэмжлэгдсэн нягтлан бодогч” гэснийг “мэргэшсэн зөвлөх” гэж, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “жилийн хугацаагаар” гэснийг “түвшний зэрэглэлтэй олгоно. Нэг, хоёрдугаар түвшний зэрэглэлийг 5 жилийн хугацаагаар, 3 дугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь” гэснийг “татвар, эдийн засаг, санхүү,” гэж, 15.1.2 дахь заалтын “нягтлан бодогч” гэснийг “энэ зүйлийн 15.1.1-д заасан” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “төрийн бус байгууллага мөн” гэснийг “татварын мэргэшсэн зөвлөхүүдийн гишүүнчлэлтэй, өөрөө удирдах ёсны, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “болгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргана.” гэснийг “болгоно.” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох,” гэснийг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн тухай хууль,” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “тусгай зөвшөөрлийн үндсэн дээр” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдээс” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “нэмэлт тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 12, 13 дугаар зүйлийг, 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөх өдрөөс эхлэн татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй татварын мэргэшсэн зөвлөхүүдийг 2 дугаар түвшний зэрэглэлтэйд тооцно.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй татварын шинэчлэлийг зөвшөөрлийн талаар Засгийн газрын баримталж буй бодлоготой нийцүүлэх, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 79 аж ахуйн нэгж авч байснаас одоогоор татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хүчинтэй тусгай зөвшөөрөлтэй 41 аж ахуйн нэгж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Засгийн газраас баримталж буй тусгай зөвшөөрлийн тоог бууруулах, зах зээлийн зарчимд нийцүүлэн шударга, нээлттэй өрсөлдөөнийг дэмжих бодлоготой нийцэж, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид мэргэжлийн үйлчилгээг илүү үр ашигтай хүргэхэд чиглэсэн билээ.

Иймд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох агуулга бүхий Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл батлагдсанаар татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, тусгай зөвшөөрөлтэй холбоотой шат дамжлага, захиргааны ачаалал буурч, татвар төлөгчид үзүүлэх мэргэжлийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож байгаатай холбогдуулан, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд тусгай зөвшөөрөлтэй холбоотой шаардлага, нөхцөлийг зохицуулсан заалтуудыг хүчингүй болгох өөрчлөлтийг тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын  
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна.” гэж, 3.3.6.3-т “Төр, иргэний хамтын ажиллагааны түншлэлд үндэслэн соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварыг хамгаалан хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлнэ.” гэж, ““Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 9.3.6-д “Түүх, соёлын өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Соёлын тухай хуулийн Төрөөс соёлын талаар баримтлах бодлого болох 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад төрөөс соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлого болон бусад хэлбэрээр дэмжих бодлого хэрэгжүүлнэ гэж заасан.

Иймд дээрх хууль, бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу төрөөс соёлын үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжиж, түүх, соёлын өвийг хамгаалах хүрээнд түүх, соёлын дурсгалыг хадгалж, хамгаалж буй барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад орон сууцыг зөвхөн хүн суурьшин амьдрах зориулалттайгаар тодорхойлсон тул Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн өмчилж буй орон сууцыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлж байгаа зохицуулалтад өөрчлөлт оруулж зөвхөн иргэний өмчилж буй орон сууцыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөхөөр хуулийн төсөлд тусгалаа.

---o0o---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.8 дахь хэсэг нэмсүгэй:

“7.8.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7, 13.1.8-д заасны дагуу батлагдсан жагсаалтад туссан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж, хамгаалж буй барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас 100 хувиар хөнгөлнө.”

**2 дугаар зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “иргэн, хуулийн этгээдийн” гэснийг “иргэний” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай*

Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.23-т “татвар төлөхөөс зугтах” гэж татвар төлөгч татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл нуух зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэхгүйг гэж, мөн зүйлийн 6.1.24-т “татвараас зайлсхийх” гэж татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа татвар төлөгчийн үйлдлийг” гэж ялгамжтай тодорхойлохоор хуульчилсан.

Дээрх нэр томъёоны тодорхойлолт нь санхүүгийн хэрэгслийн олон талт байдал, эдийн засгийн хөгжлийг дагасан татвараас ашиг олох зорилготой хууль бус үйлдлүүдийг тодорхойлох орчин үеийн чиг хандлагад нийцсэн ойлголт юм. Татвараас зайлсхийх (tax avoidance) болон татвараас зугтах (tax evasion) гэх ойлголт нь төсөвт төлөх албан татварыг бууруулах үйлдэл боловч хууль эрх зүйн хувьд томоохон ялгаатай ойлголтууд юм. Өөрөөр хэлбэл татвараас зайлсхийх үйлдэл нь хуульд нийцсэн боловч угтаа татварын суурийг багасгах, татвараас ашиг олох санаагаар хэрэгждэг ба татварын алба тус үйлдэлд захиргааны хариуцлага хүлээлгэх боломжтой. Харин татвараас зугтах нь шууд хууль зөрчсөн гэмт хэргийн хэргийн шинжтэй үйлдэл билээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт “Татвар төлөхөөс зайлсхийх” хэмээх нэр томъёог хэрэглэсэн нь бусад хуулиар буюу татварын хууль тогтоомжийн “татвараас зайлсхийх” гэх ухагдахуунтай давхардаж байгаа бөгөөд үүний улмаас гэмт хэрэг ба зөрчлийн ялгаатай байдал, зөрчлөөс гэмт хэрэгт шилжих босгыг тодорхойлох об’ектив талын ялгамж нь дан ганц тус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үүссэн хохирлоор тодорхойлогдож байна. Иймд татварын гэмт хэргийг “татвараас зайлсхийх” бус “татвараас зугтах” гэж нэрлэн зааглаж бусад татварын хууль тогтоомжоор зохицуулагдах нийгмийн харилцаанд үүсэж буй эрх зүйн үр дагаврыг ч эрүүгийн гэмт хэрэгт хамааруулан ойлгох явдлыг халж, хууль хэрэглээний зохистой байдлыг бүрдүүлэх практик шаардлагатай байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүгийн хуулийг хэрэглэх эрх бүхий этгээд (мөрдөгч, прокурор, шүүгч гэх мэт) нь өөр салбарын хууль тогтоомжоос тодорхой зохицуулалтыг ишлэн хэрэглэхэд нэр томъёоны зөрүүтэй асуудал үүсэж буй хүндрэлтэй байдлыг шийдвэрлэхээс гадна татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын хооронд үүсэх чиг үүргийн давхардлыг арилгах эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн, 18.3 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн "зайлсхийх" гэснийг "зугтах" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



## ТАНИЛЦУУЛГА

*Зөрчлийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Татварын хууль тогтоомж зөрчсөн зарим төрлийн зөрчилд оногдуулах хариуцлагыг шударга ёсны зарчимд нийцүүлэн, оновчтой тодорхойлж, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүднээс Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Тодруулбал Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 8.2 дахь заалтад заасны дагуу төлбөрийн баримт олгох үүргээ биелүүлсэн боловч зөрүүтэй дүнгээр олгосон хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл нь баримт олгох үүргээ биелүүлээгүй этгээдэд оногдуулах шийтгэлийн хэмжээнээс 10 дахин өндөр байгаа нь тус хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх" гэх шударга ёсны зарчимд нийцэхгүй байх тул төлбөрийн баримт олгоогүй, эсхүл зөрүүтэй олгосон зөрчилд оногдуулах хариуцлагын дээд хязгаарыг хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 2.3-т заасан татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаах үүргээ биелүүлээгүй зөрчлийг тухайн татварын тайлангийн төрлөөс хамаарч, тайлагнах хугацаатай нь уялдуулан хариуцлагын хэмжээг уян хатан тодорхойлсон болно.

Дээрх хуулийн төсөл батлагдсанаар татварын хууль тогтоомж зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлагын механизм уян хатан болох эерэг нөлөөтэй.

---o0o---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14 дэх хэсэг, тайлбарыг нэмсүгэй:

“14.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

14.1.Тайлагнах хугацааг хуульд сар бүр тодорхойлсон татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаагаагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр;

14.2.Тайлагнах хугацааг хуульд улирал бүр тодорхойлсон татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаагаагүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр;

14.3.Тайлагнах хугацааг хуульд жил бүр тодорхойлсон татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаагаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.”

Тайлбар:Энэ зүйлийн 8.1, 8.2-т заасан торгуулийн хэмжээ нь мөн зүйлийн 8.3-т заасан хэмжээнээс хэтрэхгүй байна.

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 8.2 дахь заалтын “20” гэснийг “2” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.21-д “Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, татварын таатай орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан татвар төлөгчдөд тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тогтворжуулах татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтооно гэж заасан. Ийнхүү Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д “татварын хувь, хэмжээг тогтворжуулах” тухай тодорхойлж, мөн хулийн 13 дугаар зүйлд “татварын хувь, хэмжээг тогтворжуулах” харилцааг зохицуулдаг.

Гэвч хөрөнгө оруулалтын тухай хуульд “татварын хувь, хэмжээ” гэж тусгасан нь аж ахуйн нэгжүүдэд зөвхөн татвар ногдуулах үнэлгээнээс бодох татварын хувь, эсхүл мөнгөн мөнгөн дүнгээр тогтоосон хэмжээ (tax rate)-г бус татварын хэмжээ тооцох бусад арга аргачлал, дүрэм журмууд тогтворжуулсан мэтээр ойлгомжгүй байдал үүсэж, цаашид хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ авсан татвар төлөгч нартай холбоотой их хэмжээний үнийн дүн бүхий татварын маргаан гарах эрсдэлтэй байгаа тул Хөрөнгө оруулалтын тухай хуульд “татварын хувь хэмжээ” хэмээн тусгайлан томъёолж, хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.

Иймд Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгагдсан “татварын хувь, хэмжээ” гэснийг “татварын хувь хэмжээ” гэж өөрчлөхөөр Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль тогтоомжийг сайн дураар дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлж, хуулийн этгээд татварын байгууллагын хооронд үүсдэг хуулийн хэрэглээтэй холбоотой маргааны тоо буурах, татварын хууль тогтоомжийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.9 дэх заалтын, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.6 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь заалтын “хувь,” гэснийг “хувь” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг